



ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-АДАРГА СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/193

Баян-Адрага сум

Газар эзэмшүүлэх эрхийн дуудлага
худалдаа явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Газар зохион байгуулалт, гоедези зураг зүйн ерөнхий газрын даргын 2025 оны Аргачлал шинэчлэх батлах тухай А/188 дугаар тушаал, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Сумын 2026 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай 8 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баян-Адрага сумын Дуурлиг багт байршилтай Шатахуун түгээх газар агуулах зориулалттай 10000 квадрат метр газрын дуудлага худалдааг 2026 оны 04 дугаар сарын 21-ний өдөр цахим хэлбэрээр зохион байгуулсугай.

2.Газрын дуудлага худалдааны анхны үнийг 8,000,000 (Найман сая) төгрөгөөр баталсугай.

3.Дуудлага худалдааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг Баян-Адрага сумын газрын даамал (Т.Очирбат)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сумын Засаг даргын орлогч (Н.Ганбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  О. ПХАГВАДОРЖ

